



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 02 өдөр

Дугаар Б/15

Баян-Овоо сум

Нэмэгдэл хөлс олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 8.4 (төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох тухай), Боловсролын сайдын 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 1/554 дугаар албан бичгийг (чиглэл хүргүүлэх тухай) тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын багш, ажилчдад нэг өдрийн хоолны зардлын нөхөх төлбөрийн хэмжээг 5000 (таван мянга) төгрөгөөр тооцож олгосугай.
2. Хоолны зардлын нөхөх төлбөрийг 2026 оны 03 сарын 02-ны өдрөөс эхлэн тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.
3. Уг тушаал гарсантай холбогдуулан захирлын 2025 оны 03 сарын 20-ны өдрийн Б/13 тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЗАХИРАЛ  Ч.БОЛОРМАА



2326010041